



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ  
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,  
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160-0066  
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809  
Цахим шуудан: contact@ub-procurement.mn  
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.09.27 № 03/1886

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Тус газраас 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр зарласан Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх БОАЖЯ/20240101067 дугаартай Улсын болон орон нутгийн өмчит байгууллагын усан халаалтын зууханд техникийн шинэчлэлт хийх ажлын тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдээс тендер шалгаруулалтын баримт бичигтэй холбогдуулан ирүүлсэн тодруулгад захиалагчаас өгсөн хариуг дараах байдлаар хүргүүлж байна. Үүнд:

№	Тодруулга	Тодруулгын хариу
1	8-н байршлын ажлын зураг төслийн бүрдэл шаардлагад бие даасан эх үүсвэрийн чадлыг сонгохдоо одоо байгаа нийгмийн барилга байгууламжийн дулааны ачаалалтай уялдуулан тооцно гэж заасан байна. Энэ нь тухайн байршлын хэрэглэгчийн дулааны нийт ачаалал дээр нэмж тооцон төлөвлөж угсралтыг хийх ёстой юу	Хийн болон цахилгаан зуухны хүчин чадлыг сонгохдоо тухайн барилгын халаалтын тооцоот ачааллыг өсгөсөн ачааллаар тооцоолж суурилуулах
2	Нэмж тооцох дулааны ачааллыг ажлын даалгаварт тусгаагүй тул ямар хэмжээгээр нэмж тооцохоос хамаарч төсөвт өртөгт багтаан хийх боломжтой эсэхийг судлах шаардлага үүсэж байна.	Ажлын даалгаварт барилгын халаалтын тооцоот ачааллыг өсгөсөн ачааллаар тооцоогүй тул тодруулгаар техникийн тодорхойлолтод тооцоот ачааллыг тусган оролцогчдод хүргүүлж байгаа болно.
3	Ажлын даалгаварт үндсэн ба туслах тоноглолын техникийн үзүүлэлтийг заагаагүй тул тоноглолын төрөл, хүчин чадлыг хэрхэн сонгох вэ?	Ажлын даалгаварт тусгаагдаагүй үндсэн ба туслах тоноглолын техникийн үзүүлэлтийг тодруулгаар техникийн тодорхойлолтод барилгын халаалтын тооцоот ачааллыг байгууламж тус бүрээр хүргүүлж байгаа тул ачааллын

		хүчин чадалд хүрэлцэхүйц үндсэн ба туслах тоноглолыг сонгож суурилуулах шаардлагатай.
4	Баянзүрх дүүргийн 34-р хороонд байрлах Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн халаалтын зуухны дулааны нийт ачаалал 1,2Гкал/м3 заасан байна. Энэ байршлын шинээр хийгдэх дулааны эх үүсвэрийг нэг байршилд төлөвлөх ёстой юу? Учир нь энэ ачааллыг хангах дулааны эх үүсвэрийг түүхий нүүрснээс бусад түлшээр ажиллах зуухаар солиход хүндрэлтэй, Сэтгэцийн эрүүл мэндийн төвийн барилгууд нь алслагдсан байдаг тул нэг байршилд эх үүсвэрийг төлөвлөвөл эдийн засгийн үр ашиггүй байна.	Баянзүрх дүүргийн 34-р хороо, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь нийт барилгын халаалтын тооцоот ачаалалд төсөв хүрэлцэхгүйгээс шалтгаалан тус газрыг төслөөс хасуулах хүсэлтээ холбогдох газруудад хүргүүлсэн байна Иймд тодруулгаар хүргүүлэх техникийн тодорхойлолтод хэрэгжих газруудыг тодорхой тусган хүргүүлж байгаа болно.
5	Налайх дүүргийн 5-р хороонд байрлах усан халаалтын зуухыг шинэчлэх ажлын зураг төсөл боловсруулах, тоног төхөөрөмжийг угсрах ажлын даалгаварт одоо байгаа зуухнуудыг шинэчлэхдээ ижил зуухаар солино гэж ойлгох уу? Хэрэв тийм бол зураг төсөл заавал хийлгэх шаардлагатай юу?	“Налайх дүүргийн 5-р хорооны халаалтын зууханд тоног төхөөрөмж, нийлүүлж, угсрах” ажлыг тодруулгаар техникийн тодорхойлолтод тусган оролцогчдод хүргүүлж байгаа болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.